

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Сайныг үйлдэхээс бүү ай

Их Эзэн бидэнд Өөрийнх нь хадан гээр итгэлтэй зогсох аваас эргэлзээ, айдас арилан, сайныг хийх хүсэл өсөх болно хэмээн хэлсэн.

Хайрт ах, эгч нар аа, намайг үг хэлэх үед Их Эзэний Сүнс бидэнтэй хамт байхын төлөө би даруухнаар залбирч байна. Энэ чуулган дахь чин сэтгэлийн залбирал, сүнслэг өдөөлт бүхий номлол, тэнгэрлэг найрал дуунаас мэдэрсэн сүнсний өдөөлтийнхөө төлөө Их Эзэнд талархах талархлаар зүрх сэтгэл минь дүүрэн байна. Энэ Сүм бол Их Эзэний Сүм билээ.

Өнгөрсөн 4-р сард ерөнхийлөгч Томас С.Монсон дэлхий даяарх хүмүүсийн мөн миний зүрх сэтгэлд гүн гүнзгий нөлөөлсөн нэгэн захиасыг хуваалцсан. Тэрээр Мормоны Номын хүч чадлын талаар ярьсан бөгөөд энэ номын сургаалуудыг судалж, тунгаан бодон, амьдралдаа хэрэгжүүлэхэд биднийг уриалсан юм. Бид өдөр бүр Мормоны Номыг судалж, тунгаан бодох цаг гаргаж, зарлигуудыг нь сахивал энэ нь үнэн талаар гэрчлэлтэй болох бөгөөд уг гэрчлэл амьд Христийн талаар гэрчилж, хүнд хэцүү цагт аюулгүй тэсэн үлдэхэд тусалж чадна хэмээн

тэр амласан. (“Мормоны Номын хүч,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 73-ыг үзнэ үү.)

Та нартай л адил би бошиглогчийн үгсийг Их Эзэний надад хандаж буй дуу хоолой гэж хүлээн авсан. Мөн би та нартай адил тэдгээр үгийг дуулгавартай дагахаар шийдсэн. Ер нь би залуу хөвгүүн байхаасаа л Мормоны Ном бол Бурханы үг, Эцэг, Хүү хоёр Иосеф Смит дээр ирж, түүнтэй ярьсан, эртний төлөөлөгчид Их Эзэний Сүмд санваарын түлхүүрүүдийг сэргээхээр бошиглогч Иосеф дээр ирсэн гэсэн гэрчлэлтэй болсон юм.

Энэ гэрчлэлийнхээ ачаар би Мормоны Номыг 50 жилийн турш өдөр бүр уншиж байна. Иймээс би ерөнхийлөгч Монсоны үгс өөр хэн нэгэнд зориулагдсан юм байна гэж бодож болох байсан ч бошиглогчийн урам дэм, амлалт намайг илүү агуу хичээл зүтгэл гаргахад урьж байгааг та нартай адил мэдэрсэн билээ. Та нарын ихэнх нь надад адил илүү их хүсэлтэйгээр

залбиран, судрыг тунгаан бодож, Их Эзэнд мөн Түүний төлөө бусдад үйлчлэхийг хичээсэн.

Бошиглогчийн амласан аз жаргалтай үр дүн надад ч мөн та нарт ч ирсэн билээ. Түүний сүнслэг өдөөлт бүхий зөвлөгөөг зүрх сэтгэлдээ хүлээн авсан хүмүүс Сүнсийг илүү тодорхой сонсож сурсан. Бид уруу таталтыг эсэргүүцэх илүү агуу хүч чадлыг мэдэрч, Есүс Христ, Түүний сайн мэдээ, Түүний амьд Сүмд итгэх илүү агуу итгэлийг хүлээн авсан.

Өсөн нэмэгдсэн гэрчлэл нь улам бүр эмх замбараагүй болж буй энэ дэлхийд эргэлзээ тээнэгэлзээ, айдас хүйдсийг үлдэн хөөж, амар амгаланг авчирсан. Ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг сонсох нь надад хоёр гайхамшигт үр дүнг авчирсан юм. Нэгдүгээрт, дэлхий улам бүр ёс бус болж байгаа ч гэсэн түүний амласан Сүнс ирээдүйн талаарх өөдрөг үзлийг бий болгосон. Хоёрдугаарт, Их Эзэн надад мөн та нарт зовж шаналж буй хүмүүсийг хайрлах илүү агуу хайрыг өгсөн. Бид бусдыг авран хадгалахаар явах илүү их хүсэлтэй болсон бөгөөд уг хүсэл ерөнхийлөгч Монсоны тохинуулал, сургаалын төвд байсан юм.

Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрын хийх ажил дааж давшгүй мэт санагдах үед Их Эзэн бусдыг хайрлах хайр, эр зоригийг тэдэнд амласан. Уг эр зориг нь тэдний хад болох Их Эзэнд итгэх итгэлийнх нь дагуу ирнэ хэмээн Тэр хэлжээ.

“Сайныг үйлдэхээс бүү ай, хөвгүүд минь, учир нь та нар юу тарина, та нар мөн түүнчлэн хурааж авах

болно; тиймийн тул, хэрэв та нар сайныг таривал та нар шагналдаа түүнчлэн сайныг хурааж авах болно.

Тиймийн тул, бүү ай, бяцхан сүрэг; сайныг үйлдэгтүн; дэлхий хийгээд там та нарын эсрэг нэгдэг, учир нь хэрэв та нар миний хадан дээр баригдсан байх аваас, тэд дийлэх нь үгүй.

Болгоогтун, би та нарыг зэмлэх нь үгүй; өөрсдийнхөө замаар явж, мөн нүглийг дахин бүү үйлд; та нарт миний зарлигласан ажлыг буурь суурьтайгаар гүйцэтгэгтүн.

Санаа бодол болгондоо над уруу харатгун; бүү эргэлз, бүү ай.

Миний хажуу талыг цоо хатгасан шархыг мөн түүнчлэн миний гар мөн хөлөн дэх хадаасны ормуудыг болгоогтун; итгэлтэй байгтун, миний зарлигуудыг сахигтун, мөн та нар тэнгэрийн хаант улсыг өвлөх болно” (С ба Г 6:33–37).

Их Эзэн Сэргээлтийн удирдагчдаа мөн бидэнд Өөрийнх нь хадан дээр итгэлтэй зогсох аваас эргэлзээ, айдас арилан, сайныг хийх хүсэл өсөх болно хэмээн хэлсэн билээ. Бид ерөнхийлөгч Монсоны Есүс Христийн талаарх гэрчлэлийг зүрх сэтгэлдээ тарь гэсэн урилгыг хүлээн авснаар өөрсдийнхөө хэрэгцээг үл хайхран бусдыг аврахаар явах хүч чадал, хүсэл эрмэлзэл, эр зоригийг олж авах болно.

Би энэ итгэл, эр зоригийг зовлон бэрхшээлийг туулах үед нь итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдээс олон удаа харсан. Нэг жишээг дурдахад, 1976 оны 6-р сарын 5-нд Титон даланг нурахад би Айдаход байв. Асар их ус урсан орж ирж, олон мянган хүн гэр орноосоо дайжиж, мянга мянган орон гэр, бизнес сүйрч үгүй болсон. Гайхалтай нь, 15-аас цөөн хүн амь эрсэдсэн байв.

Би хожмын үеийн гэгээнтнүүдийг ямар ч үед Есүс Христийн тухай гэрчлэлийн хадан дээр бат бөх зогсдог болохыг олж харсан. Түүнийг өөрсдийг нь харж хандаж байгаа гэдэгт эргэлздэггүй учраас тэд айдаггүй. Тэд өөрсдийн бэрхшээлийг үл ажран бусдыг авран

хамгаалдаг бөгөөд үүнийг ямар ч хариу нэхэлгүй Их Эзэнийг хайрлах хайраараа хийдэг.

Жишээлбэл, Титон даланг нурах үед хожмын үеийн гэгээнтэн хос гэрээсээ хэдэн зуун километрийн зайд аялж байжээ. Тэд энэ тухай мэдээгээр сонсоод, Рэксбург руу яаран буцсан байна. Тэд гэр орон нь сүйрсэн эсэхийг мэдэхээр гэр рүүгээ ярахын оронд бишопоо олохоор явжээ. Тэр тусламж үзүүлэх төв болгон ашигладаг байранд байсан бөгөөд сургуулийн шар автобусаар ирсээр байгаа мянга мянган сайн дурынхныг удирдан чиглүүлэхэд тусалж байв.

Уг хос бишоп дээрээ ирээд, “Бид дөнгөж сая ирлээ. Бишоп оо, бид хаашаа явж туслах вэ?” гэж асуужээ. Тэр тэдэнд гэр бүлүүдийн нэрийг өгөв. Тэд нэг гэрээс нөгөө рүү яван, шавар шавхай, ус шалбааг зайлуулж, хэдэн өдрийн турш үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл ажилласны эцэст сая л нэг юм өөрсдийн гэр орныг шалгах завтай болсон байна. Гэр орноос нь засаж янзалчхаар юу ч үлдээгүй, бүрмөсөн урссан байсан учраас тэд бишоп руугаа дахин яаран очоод, “Бишоп оо, туслуулах хүн байна уу?” гэж асуужээ.

Эгэл даруу эр зориг, энэрэл хайрын энэхүү гайхамшиг—Христийн цэвэр хайр үеийн үед дэлхий даяар тохиолдсоор байгаа юм. Энэ нь Миссури дахь бошиглогч Иосеф Смитийн хавчлага дарамт, зовлон бэрхшээлийн аймшигт өдрүүдэд тохиолдсон. Энэ нь Бригам Янгийг Их Эзэнд Сионыг байгуулж өгөхөд нь нэг нэгэндээ туслахын тулд Наувугийн дүрвэгчдийг удирдан, Нэгдсэн Улсын баруун хэсгийг хөндлөн гулд туулан эзлүүд газар руу явахаар гэгээнтнүүдийг дуудах үед тохиолдсон юм.

Хэрэв та нар тэдгээр анхдагчийн тэмдэглэлийг бүхлээр нь уншвал эргэлзээ, айдсыг итгэлээр орлуулсан гайхамшигийг харах болно. Та өөрсдийнхөө хонь мал руу мөн хагалж ч амжаагүй талбай руугаа

буцахын оронд Их Эзэний төлөө хэн нэгэнд туслахаар хувийн асуудлуудаа хойш тавьсан гэгээнтнүүдийн талаар унших болно.

Хэд хоногийн өмнө Пуэрто-Рико, Сэйнт Томас, Флоридад болсон Ирма хар салхинаас үүдэлтэй гайгамшгийн дараа би энэхүү гайхамшигийг харсан. Тэнд өөр сүмийнхэн, орон нутгийн олон нийтийн бүлгэмүүд, улсын байгууллагуудтай хожмын үеийн гэгээнтнүүд хамтран цэвэрлэх ажлыг эхлүүлжээ.

Рэксбург дахь найзуудын маань адил Флоридад нэгэн гишүүн бус хос өөрсдийн эдлэн газарт ажиллалгүй олон нийтэд туслахад анхаарлаа төвлөрүүлсэн аж. Хожмын үеийн гэгээнтэн хөршүүд нь замыг нь хааж унасан хоёр том модыг зөөж холдуулахад тусалъя гэхэд тэр хос хэрхэн цочирдсоноо мөн гэр оронд нь хэрэгтэй тусламжаа авна гэдэгт Их Эзэнд найдсан тул бусдад туслахаар явсан гэдгээ тайлбарлажээ. Дараа нь Сүмийн гишүүдийг ирж, тусламж үзүүлэхээс өмнө тэд залбирсан гэдгээ нөхөр нь хэлэв. Тэдэнд тусламж авна гэсэн хариу ирсэн бөгөөд тусламж нь ч хэдхэн цагийн дотор ирсэн байна.

Зарим хүн Тусламжийн гар гэсэн бичигтэй шар цамц өмссөн хожмын үеийн гэгээнтнүүдийг “Шар тэнгэр элч” гэж дуудаж эхэлсэн талаарх мэдээг би сонссон. Хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйн машинд засвар үйлчилгээ хийж байсан залуу шар цамц өмссөн хүмүүс хашаанд нь унасан модыг холдуулахад туслаад, “надад Бурханы хүүхэд байх тухай дуу дуулж өгсөн” хэмээн өөрт тохиолдсон “сүнслэг туршлагаа” хуваалцсан аж.

Манай шашны бус Флоридогийн өөр нэгэн оршин суугч нурж сүйдсэн хашаагаа цэвэрлэж янзлах, аргаа олж ядан мухардаж, ядарч туйлдан, нулимс цийлгэнүүлэн сууж байхад нь хожмын үеийн гэгээнтнүүд гэрт нь ирсэн талаар хэлсэн юм. Сайн дурынхан түүний хэлснээр “гайхамшигийг бүтээсэн” байв. Тэд хичээнгүйлэн туслахын

зэрэгцээ инээлдэн хөөрөлдөж, хийсэн ажлынхаа оронд ямар ч хөлс аваагүй гэнэ.

Би бямба гаргийн орой Флорида дахь хожмын үеийн хэсэг гэгээнтнүүд дээр зочлохдоо тэрхүү хичээл зүтгэлийг харж, инээд хөөрийг сонсон юм. Тэдгээр сайн дурынхан хэсэгхэн хугацаанд цэвэрлэгээний ажлаасаа амсхийн надтай гар барин мэндлэв. Жоржиа дахь гадасных нь 90 гишүүн өмнөх орой нь Флорида дахь аврах ажилд нэгдэх төлөвлөгөө гаргасныг тэд хэлсэн юм.

Тэд үүрийн 4:00 цагт Жоржиагаас гарч, олон цагийн турш машинаар яван, өдөржин шөнөжин ажилласан ч дараагийн өдөр нь дахин ажиллахаар төлөвлөжээ.

Тэд энэ бүхнийг нүүрэндээ инээмсэглэл тодруулан, хошин байдлаар дүрсэлж байв. Тэд ажилдаа эргэн орохын тулд хүмүүсээс талархлын үг сонсохоос татгалзаж байсан нь миний онцгойлон ажигласан ганц асуудал байв. Гадасны ерөнхийлөгч цахилгаан хөрөөгөө асаагаад, унасан модыг тайрч байхад бишоп биднийг дараагийн аврах багийнхан руу явахаар машиндаа суух үед модны мөчрүүдийг тайрч янзалж байв.

Өмнө нь, биднийг өөр нэгэн газраас хөдлөх үед нэгэн эргэтэй биднийг чиглэн ирээд, малгайгаа аван, сайн дурынханд талархал илэрхийлсэн юм. Тэр “Би танай сүмийн гишүүн биш ээ. Та нарын бидний төлөө хийсэн зүйлд итгэж ч чадахгүй нь. Бурхан та нарыг адислаг” гэж хэлэв. Түүний хажууд зогсож байсан шар цамцтай ХҮГ сайн дурын үйлчлэгч магтаал сайшаал хүлээн авах эрхгүй мэт инээмсэглээд, мөрөө хавчиж харагдсан.

Жоржиагийн сайн дурынхан итгэж ядан байгаа энэ эрд туслахаар ирсэн байхад Флоридагийн хар салхинд нэлээд хүнд нэрвэгдсэн хэсгээс зуу зуун хожмын үеийн гэгээнтэн Флоридагийн өөр нэг хэсэг рүү хүмүүсийг илүү хүнд байдалд байгааг сонсоод хэдэн зуун километр аялж очжээ.

Тэр өдөр би бошиглогч Иосеф Смитийн хэлсэн “Бурханы хайраар дүүрсэн хүн зөвхөн гэр бүл нь адислагдсанд сэтгэл ханадаггүй, харин бүх хүн төрөлхтнийг адислахад санаа тавин дэлхий даяар явдаг” гэх бошиглолын үгсийг санаж, илүү сайн ойлгосон билээ. (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 426).

Бид ийм хайрыг аль ч газрын хожмын үеийн гэгээнтнүүдийн амьдралаас хардаг. Дэлхийн хаа нэгтээ гай гамшиг тохиолдох бүрд хожмын үеийн гэгээнтнүүд Сүмийн хүмүүнлэгийн үйлсэд хандив өргөж, сайн дураараа үйлчилдэг. Сайн дурынхныг эрж хайх шаардлага бараг л гардаггүй. Бүр зарим тохиолдолд сайн дурын ажлыг удирдаж буй хүмүүс сайн дурынхныг хүлээн авахад бэлэн болох хүртэл тусламж хэрэгтэй газар руу аялахаа түр азнахыг сайн дурынхнаас хүсэх шаардлага гардаг.

Бусдыг адислах хүсэл нь Есүс Христ, Түүний сайн мэдээ, сэргээгдсэн Сүм, бошиглогчийн тухай гэрчлэлтэй хүмүүсийн үр жимс юм. Үүний ачаар Их Эзэний хүмүүс эргэлздэггүй мөн айдаггүй. Мөн номлогчид дэлхийн өнцөг булан бүрд үйлчлэхээр сайн дураараа ирдэг. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт бусдын төлөө залбирдаг. Удирдагчид Мормоны Номыг гүн гүнзгий судлах ерөнхийлөгч Монсоны хүсэлтийг чин сэтгэлээсээ хүлээн авахад өсвөр үеийнхнийг урьдаг. Уг үр жимс нь удирдагчдаас урилга авснаар биш, харин золиослол гаргах байсан ч итгэлээрээ үйлддэг өсвөр үеийнхэн, гишүүдээс ирдэг юм. Амин хувиа үл хичээсэн золиослолыг шаардаг үйлдэл болсон итгэл нь Бурханы хайрыг мэдрэх боломжийг олгох зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчирдаг.

Биднийг бошиглогчийн зөвлөгөөг үргэлжлүүлэн дагах үед зүрх сэтгэл маань өөрчлөгдсөн хэвээр үлддэг юм. Бид зөвхөн ганц удаа чухал хичээл зүтгэл гаргачихаад

больчихвол уг өөрчлөлт алгуур үгүй болох болно.

Итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүд Их Эзэн Есүс Христэд болон Бурханы үг болох Мормоны Номонд мөн Түүний үнэн Сүм дэх санваарын түлхүүрүүдийн сэргээлтэд итгэх итгэлээ өсгөсөн байдаг. Энэхүү өсөн нэмэгдсэн гэрчлэл биднийг Бурханы хүүхдүүдийг гэсэн илүү агуу эр зориг, анхаарал халамжтай болгосон. Гэвч ирээдүйд биднийг хүлээх сорилт бэрхшээл, боломжууд үүнээс хавьгүй ихийг шаардах болно.

Бид нарийвчилсан зургийг харж чадахгүй ч том дүр зургийг мэднэ. Бид хожмын өдрүүдэд дэлхий үймээн самуунтай байх болно гэдгийг мэднэ. Ямар ч зовлон бэрхшээл тохиолдсон бай, Их Эзэн итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдийг Есүс Христийн сайн мэдээг бүх үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүст хүргэхээр удирдах болно гэдгийг бид мэднэ. Мөн бид Их Эзэний жинхэнэ шавь нар Түүнийг дахин ирэх үед хүлээн авахуйц зохистой мөн бэлэн байх болно гэдгийг мэднэ. Бид айх хэрэггүй.

Бид зүрх сэтгэлдээ итгэл, эр зоригийг хэдийн суулгасан ч Их Эзэн биднээс мөн бидний дараах үеийнхнээс илүү ихийг шаардах болно. Тэд биднийхээс илүү агуу мөн хэцүү ажлыг хийх учраас илүү хүчирхэг, зоригтой байх ёстой. Тэд бодгалийн дайсны илүү их эсэргүүцэлтэй тулгарах болно.

Их Эзэн ирээдүйн талаар өөдрөг байх арга замыг өгсөн. “Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай” (С ба Г 6:36). Ерөнхийлөгч Монсон бидэнд яаж гэдгийг харуулсан. Бид Мормоны Ном, бошиглогчдын үгсийг тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой. Ямагт залбир. Итгэсээр бай. Түүнд бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа үйлчил. Бид энэрэл буюу Христийн цэвэр хайрын төлөө зүрхнийхээ бүхий л эрч хүчээр залбирах ёстой (Моронай 7:47–48-ыг үзнэ үү). Мөн

юу юунаас илүү бид бошиглолын зөвлөгөөг дагахдаа тууштай байх ёстой.

Хүнд хэцүү цагт бид ерөнхийлөгч Монсоны Аврагчийн эдгээр үгийг эш татахдаа бидэнд сануулдаг амлаалт буюу Их Эзэний амлаалтад итгэж найдаж болно. “Мөн та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн, тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88).

Их Эзэн та нарыг Өөрийнх нь зараалд байгаа цагт та нарын


нүүрний өмнө явах болно гэдгийг би гэрчилж байна. Зарим үед та нар Их Эзэний бусдыг өргөхөөр явуулсан тэнгэр элч байх болно. Харин заримдаа та нар өөрсдийг тань өргөн дэмжүүлэхээр явуулсан тэнгэр элчүүдийн дунд байх болно. Ариун ёслолын залбирал бүрд амладагчлан, та нар Түүний Сүнснийг үргэлж зүрх сэтгэлдээ байлгах болно. Та нар Их Эзэний зарлигуудыг дагахад л хангалттай.

Хамгийн сайн сайхан ирээдүй дэлхий дээрх Бурханы хаант улсыг хүлээж байна. Эсэргүүцэл сэргөлдөөн нь чухамхүү бошиглогч Иосеф Смитийн өдрүүдээс хойш байсанчлан Есүс Христэд итгэх бидний итгэлийг хүчирхэгжүүлэх болно. Итгэл үргэлж айдсыг ялдаг. Хамтдаа хөдөлмөрлөх нь эв нэгдлийг бий

болгодог. Хайраар дүүрэн Бурхан тусламж хэрэгтэй хүмүүсийн төлөөх залбирлыг чинь сонсож, хариулна. Тэр үүрэглэх ч үгүй, унтах ч үгүй.

Бурхан Эцэг амьд бөгөөд та нарыг Өөр дээр нь гэртээ ирээсэй хэмээн хүсдэг гэдгийг би гэрчилж байна. Энэ бол Их Эзэн Есүс Христийн үнэн Сүм. Тэр та нарыг мэддэг, хайрладаг мөн харж ханддаг. Тэрээр та нарын болоод миний нүглийг, Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдийн нүглийг цагаатгасан. Амьдралдаа мөн бусдад үйлчлэх үйлчлэлдээ Түүнийг дагах нь мөнх амьдралд хүрэх цорын ганц зам билээ.

Би үүнийг гэрчлэхийн хажуугаар та бүхэнд адислал, хайраа үлдээж байна. Есүс Христийн ариун нэрээр, амен.



Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Эгч дүү гурав

Шавь байх нь бидний өөрсдийн үүрэг хариуцлага бөгөөд бусад хүний бидэнтэй яаж харьцаж байгаагаас шалтгаалахгүй.

Хүндэт эгч нар аа, хүндэт найзууд аа, Ерөнхий чуулганыг дэлхий даяарх эгч нарын хуралдаанаар эхлэх нь чухал ач холбогдолтой бас гайхалтай юм. Бүх насны, өөр өөр гарал үүсэл, яс үндэс, хэлтэй эгч нар Есүс Христэд итгэх итгэл, Түүнийг гэсэн хайраараа нэгдсэн байна гээд зүгээр л төсөөлөөд үз.

Биднийг саяхан хайрт бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсонтой уулзах үед тэрээр Их Эзэнд ямар их хайртайгаа бидэнд хэлсэн билээ. Ерөнхийлөгч Монсон та нарын хайр, залбиралд мөн Их Эзэнд үнэнч байдагт маш их талархдаг гэдгийг би мэднэ.

Эрт урьд цагт алс хол нутагт эгч дүү гурав амьдардаг байжээ.

Ууган эгч нь гунигтай байдаг байв. Хамраас нь авахуулаад эрүү, арьс, бүр хөлийн хуруу нь хүртэл бүгд өөрт нь хангалтгүй санагдаг байжээ. Түүнийг заримдаа эв хавгүйхэн ярихад хүмүүс инээлддэг байж гэнэ. Хүмүүс түүнийг шүүмжилж эсвэл ямар нэг зүйлд урихаа “мартвал” нүүр нь улайж, холдож яван, нууц газар очоод гунигтайгаар санаа алдаж, амьдрал яагаад

ийм баргар бас баяр хөөргүй байдгийг гайхаж суудаг байжээ.

Удаах эгч нь *ууртай* байдаг байв. Тэр өөрийгөө маш ухаантай гэж боддог боловч хэн нэгэн сургуулийн шалгалтан дээр үргэлж өөрөөс нь өндөр оноо авдаг байлаа. Тэр өөрийгөө хөгжилтэй, үзэсгэлэнтэй, загварлаг, дур булаам гэж боддог байв. Гэвч өөрөөс нь илүү хөгжилтэй, үзэсгэлэнтэй, загварлаг, дур булаам хэн нэгэн үргэлж байдаг мэт түүнд санагддаг байжээ.

Тэр ямар ч зүйлд шилдэг нь байгаагүй ба үүнийг тэвчдэггүй байлаа. Түүнийхээр амьдрал ийм байх ёсгүй байв.

Заримдаа тэр бусдад уурладаг байсан ба тэр үргэлж л ямар нэг зүйлээс болж уурлахад бэлэн явдаг байлаа.

Энэ нь түүнийг илүү сэтгэл татам эсвэл нэр алдартай болгоогүй нь мэдээж. Заримдаа тэр шүдээ зууж, нударга зангидан, “амьдрал шударга биш байна” гэж боддог байв.

Отгон дүү нь гунигтай, ууртай эгч нартайгаа адилгүй байлаа. Тэр баяртай байдаг байжээ. Тэр эгч нараасаа илүү ухаантай эсвэл үзэсгэлэнтэй байсан учраас баяртай

байгаагүй. Хүмүүс заримдаа түүнээс зайлсхийж эсвэл түүнийг үл ойшоодог байсан. Тэд заримдаа түүний өмсөж зүүсэн эсвэл хэлж буй зүйлсийг шоолдог байлаа. Тэд заримдаа түүнтэй бүдүүлэг харьцаж эсвэл өөрийнх нь талаар найрсаг бус зүйл ярьдаг байжээ. Гэхдээ эдгээрийн алинд ч тэр тийм ч их санаа зовдоггүй байв.

Тэр дуулах дуртай байсан. Түүнд сайхан хоолой заяагаагүй бас хүмүүс доог тохуу хийж байсан ч тэр дуулахаа болиогүй. “Би бусад хүний бодлоос болоод дуулахаа болихгүй” гэж тэр хэлдэг байв.

Түүнийг дуулсаар байсанд ууган эгч нь гуниглаж, удаах эгч нь уурлажээ.

Олон жил өнгөрч, эгч дүү гурав энэ хорвоог орхих цаг болж гэнэ.

Амьдралд сэтгэл гонсойлгодог олон зүйл байдгийг олж мэдсэн ууган эгч нь гунигтай чигээрээ насан өөд болов.

Өдөр бүр дургүй хүргэх ямар нэг зүйлийг олдог байсан удаах эгч нь *уурласаар* нас барсан гэдэг.

Отгон дүү нь насан туршдаа дуугаа бүх чадлаараа дуулж, нүүрэндээ итгэл дүүрэн инээмсэглэл тодруулсаар баяр жаргалтай нас баржээ.

Амьдрал хэзээ ч ийм энгийн мөн хүмүүс энэ түүхэн дэх эгч дүү гурвын хэмжээнд байгаад байхгүй нь мэдээж. Гэсэн хэдий ч ийм эрс тэс жишээ бидэнд өөрсдийн маань тухай ямар нэг зүйлийг ойлгуулж чадна. Хэрэв та бидний ихэнхтэй нь адил бол, магадгүй та эдгээр эгч дүүсийн аль нэгээс, хоёроос нь ч юм уу гурвуулангаас өөрийгөө олж харсан байж болно. Эдгээрийг нэг нэгээр нь нарийвчлан авч үзье.

Хохирогч

Ууган эгч нь өөрийгөө хохирогч буюу өөрийнхөө төлөө үйлдэх чадваргүй гэж үзсэн.¹ Амьдралд нь шил шилээ даран тохиолдсон зүйлүүд түүнийг зовлонтой болгож байсан мэт түүнд санагдсан. Амьдралд ингэж хандсанаар түүний сэтгэл санаа, зан авир бусдаас хамааралтай болсон юм. Бид ийм байвал үзэл бодлын салхи болгонд туугдаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн энэ эрин үед эдгээр салхи далайн шуурга адил хүчтэй шуурдаг.

Хүндэт эгч нар аа, та нар яагаад өөрсдийн аз жаргалыг та нарт эсвэл та нарын аз жаргалд өчүүхэн санаа тавьдаг хэн нэгэн эсвэл хэсэг бүлэг хүнд найр тавин өгөх ёстой юм бэ?

Хэрэв та бусад хүнийг өөрийн тань тухай юу гэж ярьж байгаа бол гэдэгт санаа зовж байгаа бол хэн гэдгээ санах нэгэн анагаах эмийг би санал болгоё. Та бол Бурханы хаант улсын хааны гэр бүлийн гишүүн, орчлон ертөнцийг захирдаг Тэнгэрлэг Эцэг эхийн охин гэдгээ санаарай.

Та нарт Бурханы сүнслэг ДНХ байдаг. Таны сүнсийг бүтээх үед үүсэж, мөнх бус амьдралын өмнөх урт удаан хугацаанд боловсорсон онцгой бэлгүүд танд бий. Та нар бол нигүүлсэнгүй, Тэнгэр дэх үүрдийн Эцэг, Түмний Их Эзэн, орчлон ертөнц, огторгуйн уудамд эргэлдэх оддыг бүтээж, гараг эрхсийг тойрог замд нь байрлуулсан Нэгэний хүүхдүүд юм.

Та Түүний
сайн сайхан,
хайр энэрэлт,
халамжит мутарт байна.

Таны талаар хэн ч юу ч гэж хэлсэн бай, үүнийг өөрчилж чадахгүй. Таны тухай Бурханы хэлсэн зүйлийн хажууд тэдний үгс хоосон.

Та бол Түүний хайрт охин билээ.
Тэр танд хайртай.

Та бүдчиж, Түүн рүү нуруугаа харуулсан байсан ч Бурхан танд хайртай. Хэрэв танд төөрч будилж, гадуурхагдаж, мартагдсан мэт

мэдрэмж төрж байгаа бол бүү ай. Сайн Хоньчин таныг олох болно. Тэр таныг мөрөн дээрээ өргөх болно. Тэр таныг гэрт тань аваачна.²

Хайрт эгч нар минь ээ, эдгээр тэнгэрлэг үнэнийг зүрх сэтгэлдээ сайтар шингээ. Та нар гуниглахгүй байх олон шалтгаан бий гэдгийг олж мэдэх болно. Учир нь та нарыг мөнхийн хувь тавилан хүлээж байна.

Дэлхийн хайрт Аврагч хувь тавилангаа бодитой болгох сонголт хийх боломжийг та нарт олгохын тулд амиа өгсөн. Та нар Түүний нэрийг өөрсөд дээрээ авсан шавь нар нь билээ. Түүний ачаар та нар мөнх алдар сууг хүртэж чадна.

Үзэн ядагч

Удаах эгч нь дэлхийнхнийг буруутгадаг байсан. Тэрээр гунигтай эгчийнхээ адил амьдрал дахь асуудлуудаа бүгдийг өөр хүмүүсээс болсон гэж үздэг байв. Тэр гэр бүл, найз нөхөд, дарга, хамт олон, цагдаа, хөрш, Сүмийн удирдагч, орчин үеийн хэв загвар, нарны хурц гэрэл, гай барцад зэргийг буруутгадаг байсан. Тэр энэ бүхэн рүү дайрч давшилдаг байсан ба өөрийгөө эелдэг бус хүн гэж боддоггүй байв. Харин ч эсрэгээр нь, тэр өөрийгөө хамгаалж байна гэж боддог байв. Бусад бүх хүнийг аминч үзэл, өөдгүй зан, үзэн ядалт өвөрлөдөг гэдэгт тэр итгэдэг байсан. Харин өөрийгөө шударга ёс, үнэнч шударга зан, хайр энэрэл гэх мэт сайхан санаа агуулсан гэж боддог байв.

Харамсалтай нь, уур уцаартай эгчийн үзэл бодол дэндүү элбэг байдаг. Өрсөлдөөнтэй бүлгүүдийн хоорондын зөрчлийг судалсан саяхны нэгэн судалгаа үүнийг харуулжээ. Уг судалгааг хийсэн судлаачид Ойрх Дорнодын палестинчууд ба израильчуудтай мөн Нэгдсэн Улсын бүгд найрамдахчууд ба ардчилсан үзэлтнүүдтэй ярилцлага хийсэн байна. Судлаачид “талууд өөрсдийгөө үзэн ядалтаас илүү хайраар асуудалд хандаж байгаа гэж үзсэн. Харин өрсөлдөгч тал

нь яагаад зөрчилдөөнд орсон тухай асуухад тэднийг үзэн ядалтаар асуудалд ханддаг гэж үздэг болохыг” тогтоожээ.³

Өөрөөр хэлбэл, бүлэг тус бүр өөрсдийгөө “сайн” буюу шударга, найрсаг, үнэнч гэж үзсэн байна. Нөгөө талаас, тэд өрсөлдөгчөө “муу” буюу мэдээлэлгүй, шударга бус, хорон санаатай гэж дүгнэжээ.

Намайг төрдөг жил дэлхий уй гашуу, зовлон шаналал дагуулсан аймшигт дайнд нэрвэгдээд байлаа. Энэ дайныг манай улс орны хэсэг бүлэг хүн дэгдээсэн бөгөөд тэд өөр хэсэг бүлэг хүнийг муу муухай хэмээн тодорхойлж, тэдний эсрэг үзэн ядалтыг хөхиүлэн дэмжсэн юм.

Тэд өөрсдийн дургүй хүмүүсийн амыг таглаж, тэднийг шившиглэн, ёс бус хэмээн үзсэн. Мөн тэднийг дорд үзэж, тэр ч байтугай хүнээс ч дорд үзсэн. Аливаа бүлэг хүнийг дорд үзэгсэд тэдний эсрэг үйлдсэн хэрцгий үг, үйлдлээ зөвтгөх хандлагатай байдаг.

Би 20-р зууны Германд юу болсныг бодохоор дотор зарсхийдэг.

Аливаа хүн биднийг эсэргүүцэж эсвэл бидэнтэй санал зөрөх үед тэднийг л болохгүй байна гэж бодоход амархан. Ингэсэн тохиолдолд тэдний үг, үйлдлийг хамгийн муу сэдэлтэй холбож ойлгоход амархан байдаг.

Бид үргэлж зөв зүйлийн төлөө зогсох ёстой төдийгүй үүнийхээ төлөө дуу хоолойгоо өргөх ёстой үе гардаг нь мэдээж юм. Гэсэн хэдий ч, бид зүрх сэтгэл дэх бухимдал эсвэл үзэн ядалтаар үүнийг хийх үедээ мөн бусдыг буруутгаж, шившиглэж, тэдний дуут хорих үедээ зөв шударга үйлдээгүй байх магадлал өндөр байдаг.

Аврагч юу гэж заасан бэ?

“Би та нарт хэлнэ, дайснуудаа хайрла, чамайг зүхэх тэднийг адисал, чамайг үзэн ядах тэдэнд сайныг үйлд, мөн чамайг хүнлэг бусаар ашиглах мөн чамайг хавчин гадуурхах тэдний төлөө залбир.

Та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд байж болохын тулд буюу.”⁴

Энэ бол Аврагчийн арга зам. Энэ бол дэлхийд асар их уур хилэн, үзэн ядалт, зөрчилдөөн, хүчирхийлэл бий болгодог саадуудыг нураах анхны алхам юм.

Та нар “Дайснууд маань намайг хайрлахад бэлэн байвал би тэднийг хайрлаж чадна” гэж хэлж магадгүй.

Гэхдээ тэр нь тийм ч хамаатай биш биз дээ? Шавь байх нь бидний өөрсдийн үүрэг хариуцлага бөгөөд бусад хүний бидэнтэй яаж харьцаж байгаагаас шалтгаалахгүй. Тэд хариуд нь биднийг ойлгож, хүнлэг хандаасай гэж бид найддаг нь үнэн боловч *тэднийг* хайрлах бидний хайр тэдний бидэнд хэрхэн ханддагаас шалтгаалахгүй.

Дайснуудаа хайрлах хүчин чармайлт маань тэдний зүрх сэтгэлийг зөөлрүүлж, тэдэнд сайнаар нөлөөлж магад. Үгүй ч байж магад. Гэхдээ энэ нь Есүс Христийг дагах бидний амлалтыг өөрчилдөггүй.

Тиймээс Есүс Христийн Сүмийн гишүүдийн хувьд бид дайснуудаа хайрлах болно.

Бид уур бухимдал, үзэн ядалтыг даван туулна.

Бид зүрх сэтгэлээ Бурханы бүх хүүхдийг хайрлах хайраар дүүргэнэ.

Бид тэднийг, тэр байтугай “[биднийг] хүнлэг бусаар ашиглах мөн [биднийг] хавчин гадуурхах”⁵ тэднийг адисалж мөн тэдэнд тохиулахаар гараа сунгана.

Жинхэнэ шавь

Отгон дүү нь Есүс Христийн жинхэнэ шавийг төлөөлдөг. Тэр хийхэд туйлын хэцүү зүйлийг хийсэн. Доромжлуулж, зовлон амссан ч гэсэн Бурханд итгэсэн. Эргэн тойронд нь доромжлол, сөрөг бодол байсан ч тэр итгэл, найдвараа хадгалж чадсан. Тэрээр нөхцөл байдал нь баяр хөөртэй байснаас болж биш, харин өөрөө баяр хөөртэй байсан учраас баяр хөөртэй амьдарсан.

Бидний хэн нь ч энэ амьдралыг ямар нэг эсэргүүцэлтэй тулгарахгүйгээр туулахгүй. Маш олон хүч

биднийг хойш чангааж байхад бид алсын хараагаа итгэлтэй хүмүүст амлагдсан алдар суут аз жаргал дээр хэрхэн төвлөрүүлж чадах вэ?

Энэ асуултын хариулт хэдэн мянган жилийн өмнөх нэгэн бошиглогчийн зүүднээс олдоно гэдэгт би итгэдэг. Тэр бошиглогчийн нэр нь Лихай бөгөөд түүний зүүдийг эрхэм нандин ба гайхалтай Мормоны Номонд цэдэглэсэн байдаг.

Лихай зүүдэндээ уудам тал, талд байгаа дүрслэхийн аргагүй үзэсгэлэнтэй нэгэн модыг харсан. Тэрээр түүнчлэн уг модны зүг явж буй олон бүлэг хүнийг харжээ. Тэд үүний алдар суут жимснээс хүртэхийг хүсэж байв. Энэ нь тэдэнд агуу их аз жаргал, жинхэнэ амар амгаланг өгнө гэж тэд итгэж байлаа.

Мод руу хөтөлсөн нарийн зам байх ба дэргэд нь зам дээр үлдэхэд туслах төмөр бариул байв. Эдгээрээс гадна уг зам, модыг халхлах харанхуй манан байв. Мөн ойролцоох агуу хийгээд нүсэр барилгаас сонсогдох чанга инээд, доог тохуу үүнээс ч илүү аюултай байсан болов уу. Хачирхалтай нь, тохуурхал модонд хүрч, гайхамшигт жимснээс хүртсэн зарим хүнийг ичингүйрч эхлэн, төөрч явахад хүргэсэн.⁶

Тэр хүмүүс уг мод тэдний бодож байсан шиг үнэхээр үзэсгэлэнтэй гэдэгт эргэлзэж эхэлсэн байж болох юм. Тэд мэдэрсэн зүйлийнхээ бодит байдалд эргэлзэж эхэлсэн ч байж магадгүй.

Тэд модноос холдвол амьдрал илүү амар байх болно гэж бодсон байж ч болно. Тэд дахин доромжлуулж эсвэл элэг доог болохгүй байх гэж бодсон байж болох юм.

Үнэн хэрэгтээ, тэднийг хуруугаараа зангаж байсан хүмүүс аз жаргалтай, зугаатай байгаа мэт харагджээ. Тиймээс тэд модыг орхиж явбал агуу хийгээд нүсэр барилга доторх хүмүүс тэднийг халуун дотно хүлээн авч, шийдвэр, оюун ухаан, мэргэн ухааныг нь магтана гэж бодсон байж магадгүй.

Зам дээрээ үлд

Хайрт эгч нар аа, найзууд минь, хэрэв та нарт төмөр бариулаас зууран барьж, авралын зүг тууштай алхахад хэцүү байгаа бол мөн өөрсдөдөө хэт итгэлтэй байгаа бусдын инээдэм, доромжлол таныг мохоож байвал, хэрэв хариулагдаагүй асуулт эсвэл хараахан ойлгохгүй байгаа сургаалаас болж зовж байвал эсвэл сэтгэлээр унаснаас болж гунигт автсан бол би та бүхнээс Лихайн зүүдийг санахыг гуйж байна.

Зам дээрээ үлд!

Бурханы үг болох төмөр бариулыг хэзээ ч бүү тавь!

Бурханы хайраас хүртсэний төлөө хэн нэгэн таныг ичээхийг оролдвол тэднийг бүү тоо.

Бурханы хүүхэд гэдгээ, баялаг адислалууд хүлээж байгаа гэдгийг, хэрэв Түүний хүслийн дагуу байж сурвал Түүнтэй дахин хамт амьдарна гэдгийг хэзээ ч бүү март.⁷

Дэлхийн магтаал сайшаалын амладаг зүйлүүд найдваргүй, худал бөгөөд ямар ч сэтгэл ханамж өгөхгүй. Бурханы амлалууд одоо төдийгүй үүрд баттай, үнэн, баяр баясгалантай.

Би та бүхнийг шашин, итгэл үнэмшлийг илүү өөр өнцгөөс бодож үзэхэд урьж байна. Агуу хийгээд нүсэр барилгын санал болгох юу ч Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахаас ирдэг үр жимсийг орлож чадахгүй.

Чухам “нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ.”⁸

Есүс Христийн сайн мэдээн дэх шавийн замнал нь баяр баясалд хүрэх зам гэдгийг би хувьдаа олж мэдсэн. Энэ бол аюулгүй байдал, амар амгаланд хүрэх зам. Энэ бол үнэнд хүрэх зам.

Та нар Ариун Сүнсний бэлэг, хүчээр үүнийг өөрсдөө олж мэдэж чадна гэдгийг би гэрчилж байна.

Хэрэв уг зам хэцүү санагдах аваас та нар Сүмийн гайхалтай бүлгүүд болох Хүүхдийн хэсэг, Залуу

эмэгтэйчүүд, Халамжийн нийгэмлэгээс аюулгүй байдал, хүч чадал олно гэж би найдаж байна. Эдгээр нь цаашдын аялалд зориулсан итгэлтэй байдал ба итгэлээ шинэчлэхийн тулд түр саатах зам дагуух өртөө юм. Энэ бүлгүүд нь хамааралтай гэдгээ мэдэрч, эгч нараас болон зорилго нэгт шавь нараас урам зориг авах боломжтой аюулгүй гэр билээ.

Хүүхдийн хэсэгт сурч мэддэг зүйлүүд нь залуу эмэгтэйн хувьд сурах нэмэлт үнэнүүдэд та нарыг бэлтгэдэг. Залуу эмэгтэйчүүдийн ангид хийдэг шавийн замнал тань Халамжийн нийгэмлэг дэх нөхөрлөл, эгч дүүгийн холбоо руу хөтөлдөг. Уг зам дээрх алхам тутамд итгэл, нинжин сэтгэл, энэрэл, ариун журам, үйлчлэлийн үйлсээр дамжуулан бусдыг хайрлах хайраа харуулах боломж та нарт олддог.

Энэхүү шавийн замыг сонгох нь хязгааргүй аз жаргал руу хөтөлж, тэнгэрлэг шинж чанарыг чинь бодитой болгоно.

Энэ нь амаргүй байх болно. Энэ нь та нараас өөрт буй эрхэм бүхнийг буюу бүх оюун ухаан, бүтээлч сэтгэлгээ, итгэл, үнэнч байдал, хүч чадал, шийдэмгий байдал, хайрыг шаардана. Хэзээ нэгэн өдөр та нар гаргасан хүчин чармайлтаа эргэн хараад, хүчтэй

хэвээр төдийгүй итгэлтэй байж, замаасаа хазайгаагүйдээ маш их талархах болно.

Урагш тэмүүл

Амьдралд та нарын хяналтаас гадуур олон зүйл байж болно. Гэвч эцсийн эцэст, хүрэх газраа мөн замын турш хуримтлуулах туршлагын ихэнхийг нь сонгох хүч та нарт бий. Та нарын чадвараас илүүтэй сонголтууд чинь амьдралд өөрчлөлт гаргадаг.⁹

Та нар нөхцөл байдлаас болж гуниглаж болохгүй.

Мөн үүнээс болж уурлаж бухимдаж болохгүй.

Та Бурханы охин гэдэгтээ баясаж болно. Та нар Бурханы ач ивээл ба Есүс Христийн хайраас баяр баясал, аз жаргалыг олж чадна.

Та нар баяр хөөртэй байж чадна.

Би та бүхнээс Бурханы элбэг дэлбэг, хязгааргүй сайн сайханд талархах талархлаар зүрх сэтгэлээ дүүргэхийг гуйж байна. Хайрт эгч нар аа, та нар үүнийг хийж чадна. Та нарыг амьдралын модны зүт урагшлах сонголтыг хийгээсэй хэмээн би бодгалийнхаа бүхий л хүслээр залбирч байна. Та бүхэн дуу хоолойгоо өргөж, амьдралдаа магтаал өргөх сонголт хийж, Бурханы хайр, Түүний Сүмийн гайхамшгууд, Есүс Христийн сайн мэдээний

дэлхийд авчирч чадах зүйлүүдэд баясах болтугай хэмээн би залбирч байна.

Жинхэнэ шавь байх нь зарим хүнд ая тухгүй эсвэл амаргүй байж болно. Энэ нь цаг хугацааны эхлэлээс ийм байсаар ирсэн.

Гэвч Тэнгэрлэг Эцэгт мөн Түүнийг хайрлаж, хүндэддэг хүмүүст энэ нь хамгийн үнэ цэнтэй, сайхан буюу Бурханыг болон бусдыг хайрлаж, үйлчлэх гэтэлгэх хайрын яруу хийгээд ариусгагч дуу юм.¹⁰

Та бүхэн Бурханы охины хувьд шавийн алдар суут замаар өдөр бүр баяртай алхахдаа баяртайгаар өсөж хөгжих хүч чадал, зоригийг олох болтугай хэмээн би Их Эзэний төлөөлөгчийн хувьд та нарт адислааа үлдээж байна. Есүс Христийн ариун нэрээр, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. 2 Нифай 2:14, 26-г үзнэ үү.
2. Лук 15:4–6-г үзнэ үү.
3. Boston College, “Study Finds Intractable Conflicts Stem from Misunderstanding of Motivation,” *Science Daily*, 2014 оны 11-р сарын 4, sciencedaily.com.
4. Матай 5:44–45.
5. Матай 5:44.
6. 1 Нифай 8-ыг үзнэ үү.
7. “Би Бурханы хүүхэд,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 58-р хуудсыг үзнэ үү.
8. 1 Коринт 2:9.
9. “The Most Inspirational Book Quotes of All Time,” pegasuspublishers.com/blog-ийг үзнэ үү.
10. Алма 5:26-г үзнэ үү.